

**Дорнод аймгийн боловсролын багш,  
удирдах ажилтнуудын явагдсан**

**СЭТГЭХ ЧАДВАР-2021**


**Хоёрдугаар онлайн уралдаан**

**2021.05.29**

1.

Кенгуру хаана байгааг олоорой.

- А) Тойрог дотор, квадратын гадна.
- В) Тойрог дотор, квадратын дотор.
- С) Квадратын дотор, тойргийн гадна.
- Д) Тойргийн гадна ба квадратын гадна.
- Е) Тойргийн дотор биш ба квадратын дотор.




Кенгуру тойрог дотор мөн квадратын гадна талд байгаа нь зургаас шууд харагдаж байна.

2.

Саруул жижиг кубууд ашиглан нэгэн том куб өржээ. Уг кубыг баруун талд үзүүлсэн байна. Дараа нь тэр хэдэн жижиг куб хасаж зүүн талд байгаа биетийг үүсгэв. Тэгвэл Саруул хэдэн жижиг куб хассан бэ?



- А) 6
- В) 8
- С) 10
- Д) 12
- Е) 14



Хасагдсан биет  $2 \times 2 \times 3$  хэмжээтэй параллелопипед байгаа нь ойлгомжтой. Иймд  $2 \times 2 \times 3 = 12$  жижиг куб хассан байна.

3.

Сарнай шоог дөрвөн удаа орхиход нийт буусан нүднүүдийн нийлбэр нь 23 байжээ. Тэгвэл “6 нүд” хэдэн удаа буусан бэ?


- A) 0      B) 1      C) 2       D) 3      E) 4

Дөрвөн удаа орхиход бүгд 6 буусан гэвэл нүднүүдийн нийлбэр 24 болно. 4 удаа 5 буусан бол нийлбэр нь 20 болох ба хамгийн зохимжтой хувилбар  $6+6+6+5=23$  буюу 6 нүд 3 удаа бууна.

4.

Шоколадны нүднүүд ижилхэн хэсгүүдээс тогтоно. Ганаа шоколад хуваав. Ингэхдээ эхлээд 5 нүдтэй нэг эгнээг ахдаа, дахин 7 нүдтэй нэг эгнээг эгчдээ өгчээ (зурагт үзүүлсэний дагуу). Тэгвэл нэг бүтэн шоколад хэдэн нүдтэй вэ?

- A) 28      B) 32      C) 35       D) 40      E) 54



Тэгш өнцөгт хэлбэртэй шоколад ба өргөний хэмжээтэй буюу 5 нүдийг ахдаа, уртын хэмжээнээс 1-ээр бага буюу 7 нүдийг эгчдээ өгсөн байна. Иймд шоколадны урт 8 нүднээс бүрдэнэ. Иймд бүтэн шоколад нь  $8 \times 5$  нүднээс тогтсон тэгш өнцөгт хэлбэртэй байна.  $8 \times 5 = 40$  нүднээс тогтоно.

5.

Тэгш өнцөгтийн нэг тал нь 8см, нөгөө тал нь энэ талынхаа хагастай тэнцүү. Тэгвэл энэ тэгш өнцөгтийн периметртэй адил периметртэй квадратын талын урт хэд байх вэ?

A) 4 см

 B) 6 см

C) 8 см

D) 12 см

E) 24 см


Нэг тал нь 8 , нөгөө тал нь энэ талын хагас гэхээр 4 байна. Тэгвэл уг периметр нь нь  $2(8+4)=24$  байна. Тэгвэл 24 см периметртэй квадратын тал нь 6 см байна. / квадратын 4 тал тэнцүү/


6.

Жижиг робот 1 см яваад зогсож дараагийн команд хүлээнэ. Хэрэв ♥ команд өгвөл баруун, харин ♠ команд өгвөл зүүн тийш эргэнэ. Хэрэв ♥♠♠♠♥♥ команд өгвөл робот ямар зам үүсгэн явах вэ?

A)   
эхлэх


B)   
эхлэх

C)   
эхлэх


D)   
эхлэх


E)   
эхлэх

Команд: БУНД –баруун гар тийш, гил зүүн гар тийш эргэнэ.  
Командууд: БАРУУН-ЗҮҮН-ЗҮҮН-ЗҮҮН- БАРУУН-БАРУУН гэж тайлагдана.



7.

Зөвхөн  плита ашиглан өрөөний шалыг хийе гэвэл дараах зурагнуудаас алийг нь хийж болохгүй вэ?



Өгсөн плита маань хээ нь диагональ дагуу байгаа гэдгээс D хувилбар нь талын дундажыг холбож татсан байна

8.


Усан онгоц голыг нэг удаа гатлахдаа 10 жижиг эсвэл 6 том машин гаргах даацтай. Лхагва гаригт онгоц голыг таван удаа гатлахдаа 42 машин тээвэрлэжээ. Хэдэн жижиг машин тээвэрлэсэн бэ?

A) 1    B) 12    C) 20    D) 22     E) 30

Дан жижиг машин ачсан гатлалтын тоо  $x$  гэвэл том машин ачсан гатлалтын тоо нь  $5-x$  байна.  
 $10x+6(5-x)=42$      $10x+30-6x=42$      $4x=12$      $x=3$  буюу дан жижиг машин ачсан тоо 3 удаа буюу нийт 30 жижиг машин зөөсөн.

9.

Квадрат дүрс 4 жижиг ижил кэмжээтэй квадратад хуваагддаг. Бүх жижиг квадратуудыг цэнхэр эсвэл ногоон өнгөөр буджээ. Жишээлбэл: зурагт үзүүлсэн дөрвөн дүрсийг нэг будалт гэж тооцно. Тэгвэл хэдэн ялгаатай будалт байх вэ?



5    В) 6    С) 7    D) 8    E) 9

Будалт : Бүгд ногоон, 1 ногоон 3 цэнхэр, 2 ногоон 2 цэнхэр, 3 ногоон 1 цэнхэр, бүгд цэнхэр гэсэн 5 янзын будалт байна.

10.

Хүүхдүүд элсэн тоглоомын талбайн уртыг хэмжив. Анар 15, Бат 17, Дэлгэр 12, Индра 14 алхам тус тус алхжээ. Хэнийх нь алхаа хамгийн урт вэ?

А) Анар    В) Бат    С) Индра     Дэлгэр    E) тодорхойлох боломжгүй

Тоглоомын талбайн урт нь тогтмол учир Анар 15, Бат 17, Дэлгэр 12, Индра 14 алхам хийсэн. Эндээс хамгийн цөөн алхсан нь хамгийн том /урт/ алхаж байгаа... Иймд Дэлгэрийн алхам хамгийн урт нь

11.

$60 \cdot 60 \cdot 24 \cdot 7$  үржвэр нь дараах хариултын алинтай нь тэнцүү вэ?

- А) долоон долоо хоногийн минутын тоо      В) жаран өдрийн цагийн тоо  
 С) долоон цагийн секундын тоо       нэг долоо хоногийн секундын тоо  
 Е) ходин дөрвөн долоо хоногийн минутын тоо

1 минут = 60 секунд

1 цаг = 60 минут

1 хоног = 24 цаг

7 хоног = 7 хоног гэдэг тэнцлээс  $60 \cdot 60 \cdot 24 \cdot 7$  үржвэр НЭГ ДОЛОО ХОНОГИЙН СЕКУНДЫН ТОО байна.

12.

Очир 1 – 100 хүртэл бүх эерэг бүхэл тоог дараалуулан 5 баганатай хүснэгтэд бичжээ. Түүний ах хүснэгтийн нэг хэсгийг хайчилж, зарим тоонуудыг арилгачихжээ. Доорх хүснэгтүүдийн аль нь үүний үргэлжлэл болохыг олоорой.

1	2	3	4	5
6	7	8	9	10
11	12	13	14	15
16	17	18	19	20

43							58						81				90				
			48							52											
												72									
																					94

А)

В)



D)

E)

А: 3-ээр төгссөн тоо 2-р баганад байж болохгүй.

В: 52 нь 58 гэсэн тооны доод мөрөнд бичигдэж болохгүй

Д: 1-ээр төгссөн гэсэн тоо 2-р баганад бичигдэхгүй.

Е: 0-ээр төгссөн тоо 2-р баганад бичигдэхгүй. Иймд С : нь 2-өөр төгссөн тоо 2-р, 9-өөр төгссөн тоо 4-р баганад бичигдэнэ. 72 нь 69-ийн доод мөрөнд бичигдэнэ.



13.

Жаргалын халаасанд 5 ба 10 төгрөгийн нийт 13 ширхэг зоос байв. Аль утга түүний халаасан дахь зооснуудын нийлбэр байх боломжгүй вэ?

- A) 60    B) 70    C) 80    D) 115    E) 125

5-тын зоос 12, 10-тынх 1 бүгд 13 зоос байсан гэвэл нийт дүн нь хамгийн багадаа нийлбэр нь 70 байна. Иймд 60 нь нийлбэр нь болж чадахгүй.

14.

Дижитал цаг өдөрт хэдэн удаа дөрвөн тоо нь дөрвүүлээ ижил цифртэй байх вэ? Энэ зурагт жишээ болгож хоёр өөр цифрээс бүрдсэн дижитал цагийг үзүүлэв.


- A) 3    B) 24    C) 1    D) 5    E) 12



22:22 11:11 00:00 гэсэн 3 тохиолдол байна.

15.

Дөрвөн ижил шоог зурагт үзүүлснээр байрлуулав. Шооны аль ч эсрэг хоёр талсынх нь нийлбэр 7 байна. Тэгвэл зурагт үзүүлсэн дүрс эсрэг талаасаа ямар харагдахыг доорх зурагнуудаас олоорой.





16.

Дараах тоонуудын аль нь тэгш тоо вэ?

A) 2009    B)  $2 + 0 + 0 + 9$     C)  $200 - 9$

D)  $200 \times 9$     E)  $200 + 9$

2009 нь сондгой,  $2+0+0+9=11$  сондгой,  $200-9=191$  сондгой,  $200 \times 9=1800$  тэгш,  $200+9=209$  сондгой ба иймд  $200 \times 9$  тэгш байна.

17.

Самбар дээр хоёр тоог нэмсэн байна. Тэгвэл \* -ын оронд ямар цифр байх вэ?

A) 2    B) 4    C) 5    D) 7     E) 8

4	*	14
+		
2	2	87
-----		
7	1	01

$4 \times 14 + 2287 = 7101$  гэдгээс \* нь 8 байна.

18.

Бүжгийн дугуйлан 39 хүү, 23 охинтой байв. Долоо хоног бүр хөвгүүдийн тоо 6-аар, охидын тоо 8-аар нэмэгддэг. Хэдэн долоо хоногийн дараа охид ба хөвгүүдийн тоо тэнцүү болов. Тэгвэл дугуйланд энэ үед хэдэн охид, хөвгүүдтэй болсон бэ?

A) 144    B) 154    C) 164     D) 174    E) 184

$x$  - 7 хоног өнгөрөг гэж үзье.  $39 + 6x = 23 + 8x$   $16 = 2x$   $x = 8$  буюу 8н 7 хоногийн дараа охид хөвгүүдийн тоо тэнцүү болно.  $39 + 48 = 87$  :  $23 + 64 = 87$  буюу 8н 7 хоногийн дараа нийт 174 охид хөвгүүдтэй болсон.

19.

Цамхаг нь квадрат, тэгш өнцөгт, адил талт гурвалжин хэлбэртэй гурван дүрсээс тогтоно. Гурван дүрсийн периметрууд нь тэнцүү ба квадратын тал нь 9 см. Тэгвэл тэгш өнцөгтийн талын урт хэд вэ? (Зураг хар)




- A) 4 см    B) 5 см     C) 6 см    D) 7 см    E) 8 см


3 дүрсийн периметр тэнцүү ба квадратын тал нь 9 гэдгээс периметр нь 36 байна. Иймд гурвалжны тал нь 12 байна. Тэгш өнцөгтийн урт нь 12 байна. /зурагнаас / Иймд периметр нь 36 гэдгээс богино талын урт нь 6 байна.

20.

4 тоог хоёр удаа толин ойлтоор эргүүлсэнийг зурагт үзүүлжээ. Үүнтэй адилаар 5 тоог хоёр удаа толин ойлтоор эргүүлэв. Тэгвэл асуултын тэмдэг байгаа газар ямар дүрс байгаа вэ?



- A) 2    B) 2     C) 5    D) 5    E) 5



21.

Дээрээс доош байрласан 21 од байв. Гэрлээ, Оюунаа хоёрын нэг нь дээрээс доош, нөгөө нь доороос дээш тоолов. Гэрлээ 10 гэж тоолсон од дээр тэд уулзацгаав. Энэ одыг Оюунаа хэд гэж тоолсон бэ?

- A) 13    B) 14    C) 11     D) 12    E) 10

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
1	2	3	4	5	6	7	8	9	10	Гэрлээ										
Оюунаа									12	11	10	9	8	7	6	5	4	3	2	1

22.






Эдгээр илэрхийллүүдийн утгуудаас аль нь бусдаасаа ялгаатай утгатай вэ?

- A)  $20 \times 10 + 20 \times 10$     B)  $20 \div 10 \times 20 \times 10$     C)  $20 \times 10 \times 20 \div 10$   
 D)  $20 \times 10 + 10 \times 20$      E)  $20 \div 10 \times 20 + 10$

A:  $20 \times 10 + 20 \times 10 = 200 + 200 = 400$     B:  $20 : 10 \times 20 \times 10 = 2 \times 20 \times 10 = 400$     C:  $20 \times 10 \times 20 : 10 = 4000 : 10 = 400$   
 D:  $20 \times 10 + 10 \times 20 = 200 + 200 = 400$     E:  $20 : 10 \times 20 + 10 = 2 \times 20 + 10 = 40 + 10 = 50$

23.

дүрсийг F цэгийг тойруулан  $180^\circ$  эргүүлэв. Үүний үр дүнд аль дүрс үүсэх вэ?

- A)  B)   C)  D)  E) 




90 градусаар 2 удаа эргүүлнэ.

24.

Ижил гурван шоог нийлүүлэн наав (зураг харна уу). Шооны эсрэг талсууд дээрх цэгүүдийн нийлбэр нь үргэлж 7 байдаг. Тэгвэл нийлүүлэн наасан талсууд дээр байгаа цэгүүдийн нийлбэр аль нь вэ?



- A) 12    B) 13     C) 14    D) 15    E) 16



Нийлүүлэн наасан 3 шооны 2 захын шоонуудын яг ижил байдалтай, голын шооны наалдас хэсгийн нийлбэр 7 ба 2 захын наадас хэсгийн нийлбэр 7 байна. Иймг эдгээрийн нийлбэр  $7+7=14$  байна.

25.

Өгсөн биетийг тэгш өнцөгт параллелепипед болгон гүйцээхийн тулд дараах биетүүдээс аль нь тохирох вэ?



26.

Зурагт тэнцүү 9 гурвалжнаас тогтох нэг том гурвалжин дүрсэлжээ. Хэрэв том гурвалжны периметр нь 36 см бол будагдсан зургаан өнцөгтийн периметрийг ол.

A) 6 см    B) 12 см    C) 18 см     D) 24 см    E) 30 см



Том гурвалжны периметр 36 гэдгээс талын урт 12 байна. Хар талын урт нь 4 байна. Иймд хар 6 өнцөгтийн периметр  $6 \cdot 4 = 24$  см байна.

27.

$12 + 23 + 34 + 45 + 56 + 67 + 78 + 89$  хэд вэ?

A) 389    B) 396     C) 404    D) 405    E) аль нь ч биш

8 нэмэгдхүүн байна.  $12+89=23+78=34+67=45+56=101$  байна. Иймд  $101 \cdot 4 = 404$

$1+2+3+\dots+99+100 = 1+100+2+99+\dots$   $101 \cdot 50 = 5050$  К.Гаусс 5 настайдаа бодож байсан.

28.

Эхний зуун тэгш тооны нийлбэрээс эхний зуун сондгой тооны нийлбэрийг хасахад хэд гарах вэ?

A) 0    B) 50     C) 100    D) 10100    E) 15150

$$2+4+6+\dots+198+200 - (1+3+5+\dots+197+199) = 2-1+4-3+6-5+6\dots+198-197+200-199 = 1+1+\dots+1+1=100$$

29.

Дараах тоонуудын аль нь хамгийн их утгатай вэ?

A)  $2011^1$     B)  $1^{2011}$     C)  $1 \times 2011$      D)  $1+2011$     E)  $1 : 2011$

A:  $2011^1 = 2011$     B:  $1^{2011} = 1$     C:  $1 \times 2011 = 2011$     D:  $1+2011=2012$     E:  $1 : 2011 = \frac{1}{2011}$  Эндээс хамгийн их утга нь 2012 байна.

30.

) Муур гурван өдөрт 12 хулгана барьжээ. Тэр өдөр бүр өмнөх өдөр барьснаасаа илүү тооны хулгана барьсан. Гурав дахь өдрөө эхний хоёр өдрийн нийт барьсанаас цөөн хулгана барьжээ. Муур сүүлийн өдөр хэдэн хулгана барьсан бэ?

A) 5    B) 6    C) 7    D) 8    E) 9

$x+y+z=12$   $x < y < z$   $x+y > z$  байх ба  $3+4+5=12$  гэсэн ганц хувилбар л үнэн болно. Иймд сүүлийн өдөр муур 5 хулгана барьжээ.

31. Аль тоо нь 3-д хуваагдах вэ?  
A) 2009    B)  $2 + 0 + 0 + 9$      C)  $(2 + 0)(0 + 9)$     D)  $2^9$     E) 2009

3-д хуваагдах тооны цифрүүдийн нийлбэр 3-л хуваагдана. A: 2009  $2+0+0+9=11$  B:  $2+0+0+9=11$   $1+1=2$  C:  $(2+0)(0+9)=2*9=18$   $1+8=9$  D:  $2^9 = 512$   $5+1+2=8$  E: 2009  $2+9=11$

32.  $\frac{1}{2} \cdot \frac{2}{3} \cdot \frac{3}{4} \cdot \frac{4}{5} \cdot \frac{5}{6} \cdot \frac{6}{7} \cdot \frac{7}{8} \cdot \frac{8}{9} \cdot \frac{9}{10} \cdot 1000$  илэрхийллийн утгыг ол.  
A) 250    B) 200     C) 100    D) 50    E) аль нь ч биш

$$\frac{1}{2} \cdot \frac{2}{3} \cdot \frac{3}{4} \cdot \frac{4}{5} \cdot \dots \cdot \frac{8}{9} \cdot \frac{9}{10} \cdot 1000 = \frac{1}{10} \cdot 1000 = 100$$

33. Тестийн бүх даалгаврын 85 %-ийг Жигмэд, 90 %-ийг Тогмид бодсон байна. Гэхдээ Тогмид Жигмэдээс нэг даалгавар л илүү боджээ. Энэ тест хэдэн даалгавартай вэ?  
A) 5    B) 17    C) 18     D) 20    E) 25

Жигмэд 85%, Тогмид 90% бодсон. Зөрүү нь 5% ба нэг л даалгавар илүү бодсон гэдгээс 5%-д 1 даалгавар байна. 100%-д нь 20 даалгавар байна.



34.

9-ийн  $\frac{4}{5}$ -ийг 5-ын  $\frac{2}{3}$ -аар үржвэл хэд гарах вэ?

- А) 24      В) 25      С) 26      D) 28      E) 30

9-ийн  $\frac{4}{5}$  гэдэг нь  $9 \cdot \frac{4}{5} = \frac{36}{5}$  гэсэн үг. Мөн 5-ын  $\frac{2}{3}$  нь  $5 \cdot \frac{2}{3} = \frac{10}{3}$  болно. Эдгээрийн үржвэр нь  $\frac{36}{5} \cdot \frac{10}{3} = 12 \cdot 2 = 24$

35.

Дөрвөн найз зайрмаг идэж байв.

- Мишээл Болдоос их,
- Жавхаа Вандангаас их,
- Жавхаа Болдоос бага зайрмаг иджээ.

Хамгийн их идсэнээс бага идсэнээр нь нэрсийг жагсаав. Аль хариулт нь зөв бэ?

- А) Мишээл, Жавхаа, Вандан, Болд      В) Вандан, Мишээл, Болд, Жавхаа  
 С) Мишээл, Болд, Жавхаа, Вандан      D) Жавхаа, Вандан, Мишээл, Болд  
 E) Жавхаа, Мишээл, Вандан, Болд

Эрэмбэлж гаргахын тулд өгсөн нөхцлийг сийрүүлье. Өгсөн нөхцлөөр  
 $B < M$   $B < Ж$   $Ж < Б$  гэсэн үг. Дээрхийг нэг мөрөнд оруулбал  $B < Ж < Б < M$  гэж бичигдэнэ.  
 Эсрэгээр нь  
 $M > Б > Ж > В$  буюу Мишээл, Болд, Жавхаа, Вандан

36.

Хэрэв ДАВС-АВСД бол 1369-ийн хувьд дараах хариултуудын аль нь вэ?

- А: 1396      В: 3619      С: 9361       D: 3691

ДАВС- АВСД      1369 - 3691

37. Анаграмыг тайлж бусдаасаа ялгаатай үгийг олно уу.  
А: Анха В: Оното С: Угурта  D: Нублаг

Хана тооно туурга **булган**


38. Анаграмыг тайлж бусдаасаа ялгаатай үгийг олно уу.  
А: Хойшо В: Басмар С: Гэзү  D: Маяа

Шохой самбар үзэг **ямаа**

39. Асуултын тэмдгийн оронд ямар тоо тохирох вэ?  
4 256 5 ?  
А: 526 В: 620 С: 726  D: 625

4-ыг 4 зэрэг дэвшүүлж 256 гарна. 5-ыг 4 зэрэг дэвшүүлэхэд 625 гарна

40. Өгсөн зурагт шооны талс бүр дээр эерэг тоонуудыг бичсэн байна. Эсрэг талс бүр дээрх тоонуудын үржвэрүүд нь бүгд тэнцүү болно. Тэгвэл эдгээр зургаан тооны нийлбэр байж болох хамгийн бага тоог ол.  
А. 36 В. 37  C. 41 D. 44 E. 60



5-ын эсрэг  $x$ , 15-ын эсрэг  $y$ , 10-ын эсрэг талс дээр  $z$  гэж бичигдсэн гэж үзье.  $x+y+z+30$  –нийлбэр нь хамгийн бага утга олно. Иймд  $x, y, z$  утга нь хамгийн бага байх ёстой.  
Мөн  $5x=10z=15y$  байна. гэдгээс  $x=6, y=2, z=3$  болно.  $6+2+3=11$  буюу  $x+y+z+30$  утга нь хамгийн багадаа 41 болно.

41.

Хоосон зайд тохирох цаг аль нь вэ?

5:02

7:02

7:22

9:22

9:42

?

а. 11:24

б. 09:44

в. 10:24

 11:42


д. 09:46

Цаг болон минут дээрх цифрүүдийн аль нэг нь 2-оор нэмэгдэж байна.

5:02   7:02   7:22   9:22   9:42   11:42

42.

Өгөгдсөн харгалзааг ажиглаад, эсрэг зүй тогтол бүхий хувилбарыг сонгоорой.



а.

б.


в.

д.

Дунд хэмжээтэй дүрс нь алхам тутамд зүүнээс баруун тийш шилжиж байна.

43.


Асуултын тэмдгийн оронд тоо ямар тоо байх вэ?



Дүрс доторх тоонуудын нийлбэр нь дүрсийн талуудын тоотой тэнцүү.  $10 = 5 + 4 + ?$   $? = 1$

44.

Дарааллыг аль хувилбар үргэлжлүүлэх вэ?




жижиг цагаан дугуй баруун тийш 1, зүүн тийш 2, жижиг хар дугуй зүүн тийш 1, баруун тийш 1, том цагаан дугуй зүүн тийш 1, баруун тийш 2 гэсэн хөдөлгөөн хийдэг дүрэмтэй.



45.

Асуултын тэмдгийн оронд тохирох тоог олж.



“ТОЛГОЙ” –н тоо нь 4 мөчүүдийн тоонуудын дундаж  $(4+5+2+1)/4=3$   $(17+6+3+2)/4=7$   
 $(11+?+8+3)/4=9$   $11+?+8+3=36$   $?=36-14-8=14$

46.



а.



б.



г.



д.

Эхний баганын 1-р тоог хар будалтынх нь /75/ хувиар үржүүлж дараагийн баганын 2-т, 2-р баганын 1-р тоог хар будалтынх нь хувиар /50/ үржүүлжэх эхний баганын 2-т бичнэ.

47.

18962	( 2623 )	34286
21175	( 1621 )	68124
74839	( ? )	52169


**3123**

$$7+4+8+3+9=31$$

$$5+2+1+6+9=23$$

48.

Дөрвөлжин цаасыг сумын дагуу нугалж, дүрс гарган хайчилсан. Тэгвэл цаасыг дэлгэвэл аль хувилбар үүсэх вэ?



а.

б.



г.

д.

